

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019-10-01

Тендерийн дугаар: МРЦМ/20901411

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээ хийх аргачлалын дагуу Үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй нийт барилга, байгууламж буюу үл хөдлөх хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, газарт дахин үнэлгээ хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа уурхай, салбар нэгжийн өмчлөлд буй хөрөнгөд хамаарна. Үүнд:

- “Монголросцветмет” ТӨҮГ-ын Захиргаа /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг/
- “Бор-Өндөр” УБҮ /Хэнтий аймаг Бор-Өндөр сум/
- “Зэрэгцээ” алтны үйлдвэр /Төв аймаг Заамар сум Хайлааст баг/

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ.

Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга,
- Ажиллах хүчний танилцуулга,
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/,
- Тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар баталгаажуулсан/,
- Сүүлийн 3 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ

Сонирхсон этгээд мэдүүлгээ **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем** www.tender.gov.mn хаягаар 2019 оны 10 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр
Утас: 450060-186, Факс: 458380 Имэйл хаяг: mailbox@monros.mn